

журмыг байгуулж эхэлж байх үес энэхүү уламжлалт боловсрол соёлоо хааж, марксизм ленинизмын онол шингэсэн ном, гарын авлагыг түлхүү хэрэглэж байсан⁶ хэдий ч удалгүй 1987 онд хятадын засгийн газраас Гадаад дахь хятад хэлний боловсролыг зохицуулах комисс (国家对外汉语教学领导小组) гэж байгуулагдсанаар хятад хэл, соёлыг гадаад дахинд сурталчлан таниулахтай холбогдон Күнзийн сургаалийн талаарх ном, сурах бичгийг дахин идэвхитэй анхаарах болж, дотооддоо ч мөн Күнзийн сургаалтай танилцах уламжлалт ном сурах бичгүүдээс бага дунд боловсролын хөтөлбөртөө оруулж, ашиглаж эхэлсэн байна.

Тэрхүү эртнээс улбаатай Хятадын уламжлалт соёлыг Күнзийн гүн ухаан, сургаал номлолоос ангид үзэхийн аргагүй. Күнз хэмээх нэрийг дурдахул Хятадын гүн ухааны сэтгэлгээ, уламжлалт соёлын тухай ярих хэрэгтэй болдог. Хятад хэл, соёлын боловсрол эзэмших уламжлалд хамгийн өргөн хэрэглэгдэж ирсэн гарын авлага бол Гурван үсэгт ном, Зуун гэрийн овог, Мянган үсгийн соён хэмээх гурван зүйл ном ажээ⁷.

2.1 ЗУУН ГЭРИЙН ОВОГ 百家姓

Зуун гэрийн овог хэмээх энэхүү бичиг бол Хятад үндэстний овог аймгуудын бүртгэл бөгөөд нийт 411 овгийн нэрийг Умард Сүн улс (960-1127)-ын эхэн үед анх нэгтгэн эмхэтгэсэн ажээ. Хожим нь нэмэгдсээр 500 гаруй овгийн нэрийг багтааж, үүнээс 444 нь дан овог, бусад нь давхар овгийн нэр юм. Үүнээс урьд түүхэн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн, эсвэл ам дамжин уламжлагдсаар ирсэн байна. Уг ном овог гэрийн нэрсийг дөрөв дөрвөн үсгээр жагсааж бичсэн байх бөгөөд овог тус бүрийн хэзээ, хаана, хэрхэн үүссэн түүхэн үйл явдлыг нь сурвалж бичгээс эш татан тайлбар танилцуулга хийж дагалдуулсан байдаг.

Тухайлбал, уг ном 赵 钱 孙 李; (Zhao, Qian, Sun, Li) гэж эхэлдэг. Хамгийн эхний赵 (Zhao) хэмээх овгийн тайлбарыг үзвэл,

赵, 据《通志 氏族略》, 《姓氏考略》所记: 伯益的后代造父为周穆王驾车有功, 周穆王把赵城封给他, 其子孙遂以赵为姓。⁸ (Жао овог: “Нэвтэрхий түүхийн овог удмын хураангуй” ба “Овгийн товчоон” зэрэг сурвалжид

6 批林批孔文章汇编 (一, 二), 人民出版社, 1974年

7 百家姓, 三字经, 千字文, 弟子规, 中国古典文学荟萃, 北京燕山出版社, 2009, 序言, 1页。

тэмдэглэсэн нь, Бө И-гийн удмын Зао Фү хэмээгч Жөү Мү Ван-гийн тэргийг жолоодон гавъяа байгуулсан тул Жөү Мү Ван, Жао Чэн хотыг түүнд тушааж өгснөөр Зао Фү-гийн хойч үе Жао овогтон болов) гэж тайлбарласан байна.

Энэ мэтээр бичиг үсэгт суралцаж буй хүмүүс юуны өмнө Хятад үндэстний олон овог аймгийн нэрсийг мэдэж авдаг байсан уламжлалтай байжээ. Орчин үед ч Хятад улсын бага дунд сургуулийн хүүхэд багачууд мөн “Зуун гэрийн овог”-ийг уншиж цээжилдэг, хүүхдэд зориулсан зурагт ном, гарын авлага ихээр хэвлэж дэлгэрүүлдэг. Энэхүү ном нь уран сайхны зохиомж агуулга байхгүй хэдий ч үндэсний овог угсаагаа мэдэх, өвлөн уламжлахад чухлын дээр, хятад ханз үсгийг сурах, овгийн нэрсийг тогтоох, бичих зэрэгт мөн чухал үүрэгтэй байдаг.⁹

2.2 ГУРВАН ҮСЭГТ НОМ 三字经

Гурван үсэгт ном бол мөн боловсрол эзэмших уламжлалт гарын авлагуудын нэг. Сонгодог гарын авлага ном бичгүүдийн дотроос “Гурван үсэгт ном”-ыг уншихад амархан, ойлгоход хамгийн хялбар ном гэж үздэг. Агуулгын хувьд Хятадын уламжлалт утга соёл, түүх, гүн ухаан, ёс суртахуун, ачлал тахимдуу гэх зэргийг багтаасан бөгөөд гол утга санаа нь гурван хэлхээ, таван ашдын явдлыг ойлгож, хүн болох ёсны тухай сургадаг.

Тус номд юу өгүүлдэг тухай Манжийн Найралт төв хааны арван гуравдугаар он (1691)-д хятад, манж, монгол хэлээр хавсарсан “Гурван үсэгт ном”-ын оршилд тэмдэглэсэн нь;

“Сань зы жин хэмээгч, дээш тэнгэрийн цагийн таван махбод, дөрвөн улирлаас хүмүүний хэргийн гурван товчоо, таван ашид, үе үеийн төр ёсон ... жич багыг хүмүүжүүлэх зүйл, өөд туулах дэв, сайн үг, сайн явдлыг журамлаж болох ба дууриаж болохыг нь бүрнээ эс гаргасан бээр үгүй. Түүний үг нь хэмжээтэй, түүний журам нь бүртгэл, түүний зорилт нь ойр, түүний санаа нь гүн. Үнэхээр багадаа сурах ардын эс уншваас үл болох нь буюу”¹⁰ гэжээ.

8 百家姓, 三字经, 千字文, 弟子规, 中国古典文学荟萃, 北京燕山出版社, 2009, 序言, 13页。

9 <http://baike.baidu.com/item/%E7%99%BE%E5%AE%B6%E5%A7%93/194637> 2017 оны 8 дугаар сарын 1-ний өдөр.

10 Манж, Монгол үсгээр хавсран тайлсан Сань зы жин-гийн бичиг, Манж, Монгол, Хятад гурван хэл хавсарсан сонгодог утга зохиолын цуврал, эрхлэн хэвлүүлсэн Эрхэмт, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2014, 1-3-р тал.

“Гурван үсэгт ном”-ыг унших, бичих, ойлгоход хялбарыг бодолцож гурав гурван үсгээр хэлхэж, нэгэн цогц утга санаа илэрхийлж байхаар бүтээсэн учир “Гурван үсэгт ном” гэж нэрлэсэн бололтой.

Үүнд өгүүлж буй гурван товчоо, таван ашид (三纲五常 бас гурван хэлхээ, таван үүрд гэх нь бий) гэдэг нь нэгэн багц утга санааг хураангуйлан нэрлэсэн хэллэг бөгөөд уг номыг үзэж суралцах явцад утга санааг нь мөн ойлгож мэддэг.

Гурван товчоо гэдэг нь,

1. Эзэн, түшмэлийн журам (君臣义)
2. Эцэг, хөвгүүний дотно (父子亲)

3. Эр, эмийн етэй (夫妇顺). Энэ гурвыг гурван товчоо буюу хэлхээ гэнэ. Төр ёсоо дээдлэх, өвөг дээдэс, ах захаа хүндлэх, үр ач, дүү нараа асран хүмүүжүүлэх, нөхөр ноён нуруутай, гэргий журамтай байх гэх мэт нийгмийн бүхий л харилцаа нь эцэстээ энэ гурваар хураангуйлагдана гэж үзээд гурван товчоог нийтээр сахиж чадваас тухайн гэр орон, нийгэм, улс үндэстэн хямрал зөрчилгүй байж өөдлөн дэгждэг тул, гурван хэлхээний учир холбогдлыг бүү хөнгөнөөр үзэгтүн хэмээн сургасан ажээ.

Таван ашид гэдэг нь, таван ашдын явдал буюу өдөр тутмын хэрэг явдалдаа эрхэмлэн сахиваас зохих дараах таван зүйл байна гэж үздэг бөгөөд эдгээрийг дурдах, тайлбарлах зэрэгт энэ дарааллыг алдалгүй баримталдаг байна.

1. Өршөөл (仁) (Сэтгэлийн эрдэм)
2. Журам (义) (Зохицол, сэтгэлийн нийлэлцэхүй)
3. Ёслол (礼) (Дүрэм, сэтгэлийн зүй)
4. Мэргэн (智) (Ухал, сэтгэлийн гаргалгаа)
5. Бат (信) (Зузаан, сэтгэлийн үндэс)

2.3 МЯНГАН ҮСГИЙН СОЁН 千字文

Энэ ном бол өмнө дурдсан хоёр номоос хэмжээ, агуулгын хувьд илүү өргөн, тусгайлан найруулан зохиосон ном болно. 500-аад оны эхээр Хятадын Лян улсын Ү-ди хаан 梁武帝 (502-549)-ы зарлигаар Жоу Синсы (周兴嗣) гэх хүн найруулан зохиожээ. Нийтээр мэдэхүйц

өдөр тутмын хэрэглээний хялбар ханз үсгийг сонгож, дуудлага нийцэт дөрвөн ханз нийлэн нэг өгүүлбэр болж байхаар зохиосон учир уншиж бичихэд цэгцтэй, цээжилж тогтооход хялбар байдаг. Жишээлбэл,

天地玄黄 (tiān dǔ xuān huáng) ,

宇宙洪荒 (yǔ zhǔ huīng huāng) 。

Тэнгэр, газар болбоос хөх хийгээд шар өнгөтэй.

Орчлон ертөнц хэмээх нь үзүүр хязгааргүй.

女慕贞洁 (nǚ mǔ zhēn jié) ,

男效才良 (nán xiào cái liáng) 。

Эхнэр хүн чин зоригийг сана.

Эр хүн эрдэм чадлыг сурагтун.

3. ОРЧИН ҮЕД БОЛОВСРОЛЫН УЛАМЖЛАЛАА АНХААРЧ БАЙГАА НЬ

Орчин үеийн хятад улс өөрсдийн уламжлалт гүн ухаан Күнзийн сургаалаа эргэн харж, хөрөнгө хүч зарцуулан дотооддоо төдийгүй гадаад дахинд тэрхүү үзэл сургаалаа идэвхитэй сурталчлан дэлгэрүүлж байна. Орчин үеийн бага дунд боловсролын сургалтандаа ч хэрэглэсээр байгааг Монгол дахь хятадын боловсролын төвийн мэдээллээс үзвэл, 12-15 насны сурагчдад “үзэл санаа, ёс суртахуун” гэсэн хичээл зааж, түүндээ дээр дурдсан гурван номыг ашигладаг байна¹¹. Мөн бичгийн сургаал буюу Рүжиа-г орчин үеийн боловсролын хөтөлбөртөө оруулж, 2003 оноос “Иргэний боловсролыг хөгжүүлэх хууль”-ийг баталж хэрэгжүүлсэн нь амжилттай явагдсаар сүүлийн хоёр гурван жилээс улам тогтворжиж байна.

БНХАУ-ын төр засгийн удирдагчид энэхүү уламжлалт үзэл санаагаа баримталсаар ирснийг илэрхийлэх баримтууд бий. Жишээлбэл “2000-аад оны дундуур БНХАУ-ын Ерөнхий сайд АНУ-д айлчилж, Харвардын их сургуульд лекц уншихдаа; Манай улсын төрийн бодлого эртний их сэтгэгч Күнзийн сургаал номлол дээр үндэслэж явдаг, хэмээн хэлсэн байдаг. Мөн НҮБ-ын жаран жилийн ойн нэгдсэн хуралдаан дээр БНХАУ-ын ерөнхийлөгч Ху Жиньтао илтгэл тавьж, үг хэлэхдээ; Манай улсын төрийн гадаад бодлого эртний сэтгэгч Күнзийн

11 <http://www.educhina.mn/aboutchina/detail/1111280032/> 2017 оны 8 дугаар сарын 1-ний өдөр.

сургаал дээр үндэслэж ...” 12 хэмээн мэдэгдэж байжээ.

Мөн одоогийн ерөнхийлөгч Си Жиньпин энэ талаар идэвхитэй анхаардаг хүн гэдэг нь харагддаг. Тэрээр “2009 онд гурван ч удаа Күнзийн институтийн нээлтийн ёслолд оролцож, ирээдүйд хятад улсын дэлхийд экспортлох хамгийн үр нөлөө бүхий бүтээгдэхүүн бол гутал хувцас, цахилгаан хэрэгсэл, машин техник бус, харин эртнээс улбаатай хятадын соёл байх болно”¹³ хэмээн хэлж байв.

4. ДҮГНЭЛТ

Хятад үндэстний соёл, сэтгэлгээний онцлогийг ойлгох, тайлбарлахад зайлшгүй авч үзэх зүйлсийн нэг нь хятадын боловсролын уламжлал бөгөөд түүний дотор “Зуун гэрийн овог”, “Турван үсэгт ном”, “Мянган үсгийн соён” чухал байрыг эзэлж байна. Эдгээр гарын авлагаар дамжин хятад ухааны суурь бүрэлдэн тогтож, цаашлаад Күнзийн сургаал “дөрвөн бичиг, таван ном”-д орох үүд нь болж өгдөг ажээ.

XXI зууны БНХАУ Күнзийн сургаалаа ихээр анхаарч байгаа нь социализмаасаа татгалзах гэж байгаа хэрэг биш, харин суурин тариалан соёл иргэншилд нь нийцэж, түүхийн урт хугацаанд байгалийн шалгарлыг даван туулж, боловсорч ирсэн үзэл санаагаа социализмтай уялдуулан “хятад онцлогтой социализм”-ыг хөгжүүлэхээр зорьж буй хэрэг болно.

Энэ нь үндэстний нэгдмэл сэтгэлгээг бий болгож, судлаачдын тэмдэглэж буй дэлхийд тэргүүлэх их гүрэн болох глобал зорилт¹⁴-доо хүрэх хувь хүний үзэл бодол, цаашлаад төр засгийн бодлого шийдвэрт нь шингэн бэхжиж байна.

Энэ дашрам дурдахад, өргөн уудам нутагт нүүдэллэн амьдрах Монголчуудын хувьд мөн өөрийн онцлогтоо тохирсон гэрийн сургууль, гэрийн багшаар дамжин боловсрол эзэмшдэг тогтсон уламжлал байсан тухай тэмдэглэсэн зүйлс буй. Тухайлбал, дипломатч

12 М.Чимидцэз, Өнөөдөр хятад судлал шиг чухал зүйл алга, Ярилцлага, Өдрийн сонин, дугаар 2011.04.08.

13 ... 2009年习近平主席亲自参与挂牌仪式的就有3个，未来中国向世界出口的最有影响力的产品不是衣服鞋子彩电车等有形物，而是中国文化和国学。2017 оны 8 дугаар сарын 1-ний өдөр.

14 Н.Ариунгуа, Ч.Батцэцэг, БНХАУ-ын шинэ удирдлага, шинэ бодлого, Бодлогын судалгааны цуврал №3, Улаанбаатар, 2013, 11-р тал.

Б.Жаргалсайхан монголчуудын гэрийн сургуулийн тухай өгүүлэхдээ, “...Гурван чухаг, Үлгэрийн далай, Чингисийн хоёр загал гэх мэт монгол ном зохиол уншуулж цээжлүүлнэ. ...Тус сургуульд Мандах нарны туяа, Оюун түлхүүр гэх мэт уран зохиолын ном заана. Монгол бичгийн төрөл бүрийн хичээл үзнэ. Буриадын сургуультай нийлсний дараа тоо бодлого, дэлхийн байдлын хичээл ордог болов. ...Энэхүү гэрийн сургууль нь тухайн үедээ нүүдэлчин монголчуудын амьдралд нэн таатай зохицсон нэгэн ёсны боловсролын тогтолцоо байжээ”¹⁵ гэсэн бөгөөд тэрхүү гэрийн сургуулиар өөрсдийн ёс заншил, шашин соёлын уламжлалд уялдсан ном бичиг, гарын авлага хэрэглэж, монгол хүн болох эрдэм ухаан эзэмшин боловсордог байжээ. Монгол гэрийн сургуультаан нар хятад хэл анхлан сурахдаа үүнд дурдан буй Гурван үсэгт ном, Мянган үсгийн соён зэргийг монгол орчуулгатай нь зэрэгцүүлэн хятад хэл бичигт суралцах гарын авлага болгон ашигладаг байв. Эх хэл бичгээ сайтар мэдэхийн дээр харь гадаад хэлийг гаргуун эзэмшиж байсны баталгаа болж, одоо бидний үед уламжлан ирсэн хятад зохиолын үлгэр дууриал болохуйц уран яруу, утга төгөлдөр монгол орчуулга цөөнгүй бөгөөд ийм сургалт одоо мартагдаад байгаа тухай эрдэмтэн Б.Сумъяабаатар, “...өдгөө хятад хэлний эл сонгомол сургалт манайд аль хэдийн орхигджээ.”¹⁶ хэмээн тэмдэглэсэн байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. В.Инжаннаши, Хөх судар, Улаанбаатар, 2006
2. Манж, Монгол үсгээр хавсран тайлсан Сань зы жин-гийн бичиг, Манж, Монгол, Хятад гурван хэл хавсарсан сонгодог утга зохиолын цуврал, эрхлэн хэвлүүлсэн Эрхэмт, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2014.
3. Их суртахуй, Монгол хятад хавсарсан дөрвөн бичиг, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2002.
4. Масао Онүки, Монголын үндэстэн бүрэлдэн тогтсон түүхэн явцын онцлог, Олон улсын монголч эрдэмтний IV их хурал, 1-р боть, Улаанбаатар, 1985.

15 Урианхан Б.Жаргалсайхан, Алаг жарны бодрол, Улаанбаатар, 2015, 63-66-р тал.

16 Б.Сумъяабаатар, Монгол, Солонгос, Нангиад мянган үсгийн соёлын харьцуулсан судалгаа, Улаанбаатар, 2011, 15

5. М.Чимидцэеэ, Өнөөдөр хятад судлал шиг чухал зүйл алга, Ярилцлага, Өдрийн сонин, дугаар 2011.04.08.
6. <http://baike.baidu.com/item/%E5%AD%94%E5%AD%90%E5%AD%A6%E9%99%A2/812632?fr=aladdin>; ... 2009年习近平主席亲自参与挂牌仪式的就有3个，未来中国向世界出口的最有影响力的产品不是衣服鞋子彩电汽车等有形物，而是中国文化及国学。2017 оны 8 дугаар сарын 1-ний өдөр.
7. 百家姓，三字经，千字文，弟子规，中国古典文学荟萃，北京燕山出版社，2009. <http://www.educhina.mn/aboutchina/detail/1111280032/> 2017 оны 8 дугаар сарын 1-ний өдөр.
8. <http://baike.baidu.com/item/%E7%99%BE%E5%AE%B6%E5%A7%93/194637> 2017 оны 8 дугаар сарын 1-ний өдөр.
9. Н.Ариунгуа, Ч.Батцэцэг, БНХАУ-ын шинэ удирдлага, шинэ бодлого, ШУА, ОУСХ, Бодлогын судалгааны цуврал №3, Улаанбаатар, 2013.
10. Урианхан Б.Жаргалсайхан, Алаг жарны бодрол, Улаанбаатар, 2001, 2015.
11. Б.Сумъяабаатар, “Монгол, Солонгос, Нангиад мянган үсгийн соёлын харьцуулсан судалгаа”, Улаанбаатар, 2011.
12. Я.Ганбаатар, Нангиадын согодог утга соёлын товчоон, Улаанбаатар, 2006.